

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 25 өдөр

Дугаар 01

Хархорин сум

*Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон
санхүүгийн тайлантай холбогдуулан
ТУЗ-аас гаргасан дүгнэлтүүдийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.
2. Компанийн 2025 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 25 өдөр

Дугаар 02

Хархорин сум

Ногдол ашигтай холбогдуулан

ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/2026 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгон ТОГТООХ нь:

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2025 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу 144,146.8 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2025 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 25 өдөр

Дугаар 03

Хархорин сум

*Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүдийг томилох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, компанийн дүрмийн 7.23-ийг тус тус удирдлага болгон “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр

Сандагийн Амгалан,

Баттулгын Бүрэн,

Пүрэвсүхийн Нямдорж нарыг томилсугай.

2. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр

Пүрэвийн Бишрэл,

Пүрэвийн Учрал,

Даваасүрэнгийн Ангар,

Жаргалын Энхтөр,

Ойдовсүрэнгийн Төмөрбаатар,

Пүрэвийн Халиун нарыг томилсугай.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ